

**МОНГОЛ УЛСАД ДУНД НАСНЫ ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ОНЦЛОГ, ЭРСДЭЛТ
ХҮЧИН ЗҮЙЛС. ЦЭВЭРШИЛТИЙН
НАСАНД ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙДАЛ
Дунд насанд Монгол эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн онцлог**

Судалгаанд хамрагдах тухай таниулсан зөвшөөрлийн хуудас

Монголын Менопауз, Андропаузын Зохицуулалтын Нийгэмлэгээс Монгол Улсын үндэсний хэмжээнд “Дунд насанд Монгол эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн онцлог” сэдвээр судалгааны ажил хийж, Монгол эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн байдалд нийгэм эдийн засаг, газарзүйн байрлал, амьдралын хэв маяг болон архаг өвчлөл хэрхэн нөлөөлж байгааг, мөн эдгээр хүчин зүйлс нь нөхөн үржихүйн эрүүл мэнд ба насжилтийн үүдэлтэй бэлгийн дааврын буурлын шинж тэмдгийн илрэлийн хамаарлыг судлах юм.

Дундаж наслалтын хувьд хүйсийн ялгаа аль ч улс оронд байдаг ба эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс дунджаар 4 насаар илүү амьдардаг байна. Манай улсын хувьд эмэгтэйчүүдийн дундаж наслалт эрэгтэйчүүдийнхээс 9.82 жилээр илүү байна. Монгол эрэгтэйчүүдийн зан үйл, амьдралын хэв маяг, насжилтийн үүдэлтэй бэлгийн үйл ажиллагааны хямрал, ясны сийрэгжилт, сэтгэцийн эрүүл мэнд болон өвчлөл байдал насжиж буй эрэгтэйчүүдэд анхаарал хандуулан судалгаа хийх шаардлагатай байна.

Уг судалгаа нь Монгол эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн онцлогт тохирсон эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх бодлого стратеги болон нотолгоонд суурилсан эмчилгээний заавар удирдамжийг боловсруулахад зайлшгүй чухал үндэслэл болно. Судалгааг Монгол Улсын үндэсний хэмжээнд хийж, нийслэлийн дүүргүүд, аймаг сумуудад амьдран сууж байгаа эрэгтэйчүүд өргөн хамруулж харьцуулснаар судалгаа бодит үр дүнтэй гарна.

Судалгааг олон улсын стандартын дагуу боловсруулсан асуумжийг судалгаанд оролцож буй эрэгтэй бие дааж, өөрөө бөглөх хэлбэрээр явуулна. Асуумжид зовууртай эсвэл зовуургүй, бэлгийн дааврын холбоотой аливаа шинж тэмдгүүд илэрч, эмчид хандсан, бусад архаг өвчинтэй хавсарсан эсэх, сэтгэл зүй, нийгмийн болон хувийн харилцааны талаас ямар нэг өөрчлөлт гарч байгаа эсэхийг асуумж бөглөх зааврын дагуу бөглөнө үү. Бэлгийн болон шээс ялгаруулах үйл ажиллагааны хямрал нь эрэгтэйчүүдийн зүрх судас, мэдрэл, сэтгэцийн өвчлөлийн эрсдэлийн эрт илрүүлгийн маркер (даруй 4 жилийн өмнөөс) болох тул тэдгээр хямралыг эрт тогтоосноор зүрх судас, цусан хангамжийн эмгэгийн эрсдлийг эрт илрүүлэх боломжтой юм.

Уг асуумжийн аргачлал нь олон улсын клиник эмнэлзүйн үнэлгээнд болон судалгааны ажилд хэрэглэгддэг стандарт хэмжүүр асуумж ба Монгол Улсад хийгдэхээр тохирулан хэрэглэж байгаа болно. Та энэхүү судалгаанд оролцохыг зөвшөөрч, нөхөн үржихүйн дараах насанд эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хөгжүүлэхэд өндөр хувь нэмэр оруулах тул судалгаанд идэвхтэй оролцож асуултыг үнэн зөвөөр бүрэн бөглөнө гэдэгт найдаж байна.

Та энэхүү судалгаанд оролцвол:

- Судалгааны явцад танаас авсан бүх мэдээллийг бид чандлан хадгална (Эрүүл Мэндийн Яамны Ёс Зүйн Хороогоор зөвшөөрөгдөж, судалгаа хийх нөхцлийн бүрдүүлэлтийн дагуу).

- Та судалгаанд оролцсон тохиолдолд судалгааны явцад бидний зүгээс өгөх үзлэг зөвлөгөөний ямар нэг төлбөр төлөхгүй.
- Та судалгаанд оролцсоноор эрүүл мэндийн байдалд үнэлгээ хийх, илрэх шинж тэмдгийн талаар мэдээлэлтэй болно.
- Мэдээллийг зөвхөн эрдэм шинжилгээний ажлын зорилгоор ашиглах бөгөөд судалгааны үр дүнг хэвлэлд нийтлэхдээ хувь хүнтэй холбоотой нэр хаягийг мэдээлэхгүй
- Та судалгаанд өөрийн зөвшөөрлөөр оролцох бөгөөд судалгааны явцад аливаа шалтгаанаар сайн дураараа татгалзах бүрэн эрхтэй.
- Судалгаанд оролцсон хүмүүст цаашид дунд насанд эрүүл мэндийн онцлог болон зонхилон тохиолдох эмчилгээний талаар мэдээллийг цахим хаяг, шуудангаар хүргүүлэх боломжтой.

Та дээрх мэдээлэлтэй танилцаж, судалгааны зорилтыг ойлгож, зөвшөөрч байгаа бол гарын үсэг зурна уу. Хэрэв танд ойлгомжгүй асуудал байгаа бол тодруулан асууж болно.

Та гарын үсгээ зурснаар судалгаанд өөрийн хүсэлтээр оролцож байгаагаа илэрхийлж байна.

Судалгаанд оролцогчийн овог нэр

КОД

(судалгааны асуумжийн мэдээлэл зөвхөн судалгааны КОД дугаараар хадгалагдана)

Судалгаанд оролцогчийн гарын үсэг

20... ..оны сарын өдөр

Судалгаанд оролцогчийн и-мэйл хаяг.....

Утасны дугаар.....

Судлаач:

Судалгааны явцад судалгаатай холбоотой ямар нэг асуудал гарвал

АУ-ны Доктор Батсүрэн (94044253), batsuren.ch@mmas.mn

АУ-ны Доктор Нансалмаа Н, Уролог Андрологийн Ахлах Зэргийн эмч info@mmas.mn

Б.Мягмардагва (91911958), migah@mmas.mn

нарт шууд хандах бүрэн эрхтэй.

Судалгаанд оролцож байгаад баярлалаа.